



Зориулалт

Засвар, барилга болон ахуйн ажилд ашигладаг ацетокси хатууруулах системтэй өндөр чанарын чигжээс. Битүүмжлэх, холбож бэхлэх, сүвэрхэг бус гадаргууд агаар чийг нэвтрэхээс хамгаалах; цонх хаалганы хүрээ, кабелийн сүвгийг битүүмжлэх; ариун цэврийн тоног төхөөрөмж, агааржуулалтын системийг угсрах үед заагыг битүүмжлэх; полиуретан угсралтын хөөсийг хэт ягаан туяанаас хамгаалах зориулалттай. Зэвэрдэггүй ган, аноджуулсан хөнгөн цагаан, шил, керамик хавтан, нэвчүүлсэн эсвэл лакадсан мод, эпокси, ламинат, ихэнх төрлийн будаг болон полиэстер, полиакрилат гэх мэт хуванцар материалуудад маш сайн наалддаг. Хурдан хальс үүсгэдэг. Ихэнх угаалга цэвэрлэгээний бодисуудад тэсвэртэй, хэт ягаан туяаны цацраг, агаар мандалын нөлөө, температурын өөрчлөлт болон бараг бүх эрс тэс нөхцөлд тэсвэртэй. Тиксотроп, завсарын дагуу гүлсэхгүй бас тархахгүй. Хатуурсны дараа уян хатан чанараа хадгалдаг.

Давуу тал

- Хэт ягаан туяаны цацраг болон угаалга цэвэрлэгээний бодист тэсвэртэй.
- Ашиглалтын температурын өргөн хүрээтэй: -40 °C-ээс +180 °C хүртэл.
- Гадаргуугийн хальс үүсэх хугацаа - 15-30 минут.
- Чигжээс хатуурах хурд - өдөрт 3 мм (+23 °C температурт, агаарын харьцангуй чийгшил 50 %).
- **Хуванцар савтай:** 310мл: 4 мм-ийн диаметртэй **20-22 уртааш метр.**
Шахдаг савтай: 85мл: 4 мм-ийн диаметртэй **6-6,5 уртааш метр.**

Хэрэглэх заавар

- +5 °C-ээс +40 °C температурт ажиллахыг зөвлөж байна. Чигжээсийн температур +20...25°C байх хэрэгтэй.
- Цэвэрхэн, хуурай, тослогыг арилгасан гадаргуу дээр чигжээсийг түрхэнэ.
- Ажилаа цэвэрхэн болгохын тулд гадаргууг цаасан скотчоор хамгаална.
- Завсар дахь чигжээсийг нойтон шпательгаар тэгшлэнэ.
- Тэгшилсний дараа шууд цаасан скотчыг арилгана.
- Чигжээсийг хатуурахаас өмнө багаж хэрэгсэл болон бохирдсон гадаргууг уусгагчаар (ацетон, цагаан спирт) цэвэрлэнэ.
- Хатсан чигжээсийг механик аргаар арилгана.

Чигжээсийг байгалийн чулуу (гангиг, боржин чулуу), металл гадаргуу, зэвэрсэн гадаргуу (хар тугалга, зэс, цайр, гууль), бетон, цемент, гипсдсэн гадаргуу болон тольтой ажиллахад хэрэглэж болохгүй. Аквариум болон усан доорхи завсарыг битүүмжлэхэд хэрэглэж болохгүй. Будаг болохгүй!

Хадгалах хугацаа: Хадгалах горимыг хангасан тохиолдолд 24 сар
Хуванцар савтай: 310мл Шахдаг савтай: 85 мл

KST-100 тунгалаг	KST-101 цагаан
EAN: 4606445041620	EAN: 4606445041637
ITF: 14606445041627	ITF: 14606445041634

KSK-100 тунгалаг	KSK-101 цагаан
EAN: 4606445032994	EAN: 4606445032987
ITF: 14606445032991	ITF: 14606445032984

KSK-106 Шоколадан бор RAL8017
EAN: 4606445042207
ITF: 14606445042204